

**БҮХ ТӨРЛИЙН ШАТАХУУН, ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙГ УЛСЫН ХИЛЭЭР ИМПОРТЛОХ ҮЕД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ**

№	Дагалдах баримт бичиг		Хуулийн үндэслэл	Баримт шалгах бичгийг	ААНБ-аас баримт бичгийг шаардах давтамж
	Нэр	Ямар байгууллагаас олгох			
1	Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл	УУЯ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.10.17, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль 5.2.2.	-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
2	Шингэрүүлсэн шатдаг хий импортлох тусгай зөвшөөрөл	УУЯ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.10.17, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль 5.2.2.	-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
3	Худалдааны гэрээ	-	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.3.1	-Эх хувь	Гэрээний хугацаанд 1 удаа
4	Олон улсын стандартын шаардлага хангасан гэрчилгээ	Экспортлогч талын эрх бүхий байгууллага	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.1.3.2	-Эх хувь	Импортлох тухай бүр
5	Монгол хэл дээр орчуулсан хор аюулын лавлах мэдээллийн хуудас (Material safety data sheet)	Үйлдвэрлэгч	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.1.3.3, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 стандарт 3.5	-Хуулбар хувь -Монгол хэл дээр орчуулсан байх, -Үйлдвэрлэгч нь боловсруулсан байх -Стандартад заасан зайлашгүй байх шаардлагатай мэдээллийг агуулсан байх -Тухайн баримт бичигтэй тээврийн хэрэгслийн жолооч болон нь ачаа барааг дагалдан хүмүүс танилцсан байх	Импортлох тухай бүрд шаардах ба тухайн баримт бичиг нь ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад буцааж өгнө
6	Аюултай ачааны тээвэрлэлтийг хариуцаж яваа ажилтан болон	-	Аюултай ачаа. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4978:2000 стандарт 6.20	-Эх хувь	Импортлох тухай бүр импортлох үед шалгаад аж ахуйн нэгж,

	хамгаалалтын хүмүүс тухайн ачааг дагалдаж яваа болохыг гэрчилсэн баримт, гэрчилгээ, эсхүл замын хуудсанд овог нэрээ тэмдэглүүлсэн байх				байгууллагад буцааж өгнө
7	Тээврийн гэрээ (автозам), гэрээнд холбогдох мэдээллийг хавсаргасан	-	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 3.1.1.3, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 3.1.1.2, 3.1.1.3, 3.3.15, 3.3.8	-Гэрээ, Эх хувь -Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгаль орчны болон гамшгаас хамгаалах улсын байцаагчаар хянуулсан байх -Тээвэрлэгч байгууллага, жолоочид танилцуулан гарын үсэг зуруулж, гэрээнд хавсаргасан байх	Гэрээний хугацаанд 1 удаа, Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөтэй эсэх, ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг импортлох тухай бүр шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад буцаан өгнө.

Нэмэлт мэдээлэл:

Дээр зааснаас бусад шаардлагыг №9.4.3 кодтой Газрын тосны бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудаснаас харна уу.